



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 262

Улаанбаатар хот

Шалган зааварчлах ажлын мөрөөр авах зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаанд хийсэн мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, шалган зааварчлах ажлын дүнгээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

2. Шалган зааварчлах ажлын тайланд дурдсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, өмчийн харилцааны чиглэлээр батлан гаргасан зарим тогтоол, шийдвэрийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэх, шаардлагатай тохиолдолд хүчингүй болгох арга хэмжээ авахыг Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

3. Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргал, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газар (Д.Бат-Эрдэнэ)-т дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1. Шалган зааварчлах ажлын хүрээнд илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хууль тогтоомжид нийцүүлэх ажлыг зохион байгуулах;

3.2. Дархан-Уул аймгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах чиглэлээр мөрдөж буй журам, гэрээний загвар, маягт, аргачлалыг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж, эрх бүхий этгээдээр батлуулах;

3.3. Шалган зааварчлах ажлын мөрөөр хийж гүйцэтгэсэн ажлын тайланг 2026 оны 1 дүгээр сард багтаан ирүүлэх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Н.Ганболд) -т үүрэг бοοлгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2025 оны ... сарын ...-ны өдрийн
~~20~~ дугаар тогтоолын хавсралт

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДЛЫГ
АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ, ЗӨВЛӨМЖ**

Дархан-Уул аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал (өмчлөгч), Засаг дарга, Орон нутгийн өмчийн газарт өмчийн харилцааны чиглэлээр дараах дүгнэлт, зөвлөмжийг өгч байна:

- Хөрөнгийн хөдлөл, хөдөлгөөн, зохицуулалтын асуудлыг удирдан зохион байгуулахад чиглэсэн бодлогыг тодорхойлох эрх зүйн баримт бичиг буюу орон нутаг, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дэг" боловсруулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах шаардлагатай;
- Засаг даргын захирамжаар хөрөнгийн ямар асуудлыг шийдвэрлэх, ямар асуудлыг ИТХ-ын тогтоолоор шийдвэр гаргах, ямар асуудлыг Газрын тушаалаар шийдвэр гаргах зэргийг тодорхойлж, мөн тухайн шийдвэрийн хэрэгжилтэд хэн хэрхэн хяналт тавих, эрх мэдэл, үүрэг хариуцлагыг зөв хуваарилах зэргийг тусгаж өгөх шаардлагатай;
- Орон нутгийн өмчийн газар нь шийдвэрийн ил тод нээлттэй байдлыг хангах үүднээс гарсан шийдвэрүүдийг тухай бүр өөрийн цахим хуудсанд байршуулж байх;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 37.1-д зааснаар байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд захирамжлалын, зохион байгуулалтын болон мэдээлэл, лавлагааны баримт бичгийг хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр, шаардлагатай тохиолдолд цаасан хэлбэрээр үйлдэнэ гэж заасны дагуу тухайн байгууллагаас гарч буй бүх баримтыг цахим хэлбэрээр хадгалах;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-т заасан үйл ажиллагаа бүрийг цаг тухайд нь заавал баримтжуулж байхыг анхаарч удирдлага хууль тогтоомжоор олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд удирдлагын үйл ажиллагааг баримтжуулах зорилгоор зохион бүрдүүлсэн захирамжлалын, зохион байгуулалтын, мэдээлэл лавлагааны баримт бичгийг баталгаажуулж ангилан төрөлжүүлж, хуудас бүрийг дугаарлан, дотоод товьёг, баталгааны хуудас үйлдэн, үдэж хавтаслахад бэлтгэж, батлагдсан хуваарийн дагуу жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан архивд баримт шилжүүлсэн акт үйлдэж, хадгалах, шилжүүлэх, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах, Монгол Улсын Засгийн газрын "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам" батлах тухай 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолыг дагаж мөрдөн ажиллах;
- Эрх зүйн баримт бичгийн хүчинтэй байдалд байнгын хяналт тавьж хуулийн нийцлийг хангуулах;
- Эрх зүйн баримт бичгийг системчлэх ажлыг зохион байгуулж ил тод мэдээлдэг байх;
- Хууль, тогтоомжийн нэршил, зүйл заалтыг батлагдсан албан ёсны хэлбэрээр бичих;
- Шаардлагатай дүрэм, журмуудыг хуульд нийцүүлэн яаралтай баталж дүрэм журмын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах;
- Захиргааны шийдвэр, баримт бичгийг зохион бүрдүүлэх, боловсруулахдаа хамрах хүрээ, зохицуулах харилцааны асуудлыг бүрэн тусгах,

11. Төрийн албан хэрэг хөтлөлт, захирамжлалын баримт бичигт тавигдах стандартын шаардлагыг хангах;
12. Хэл зүй, найруулга, монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлж бичих, хүч оруулсан нэр томьёо хэрэглэхээс зайлсхийх;
13. Дүрэм, журмаар зохицуулж буй үйл ажиллагааг процессын зураглал хэлбэрээр оруулах гэх мэт хялбар шийдлийг эрж хайх;
14. Дүрэм, журмаар зохицуулах харилцааг зөв тодорхойлох.;
15. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах журам”-ын 1.1.3-т “Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээллийг Үндэсний статистикийн хорооны зөвшөөрлөөр баталсан маягтаар авч, мэдээллийн цаасан архив (байнга хадгалах) болон цахим сан бүрдүүлэх гэж заасны дагуу тооллогын бүрдэл материалыг нөхөн бүрдүүлж ажиллах;
16. Албан ёсны цахим хуудас дахь мэдээллийн ил тод, хүртээмжтэй, үнэн зөв, байдлыг хангаж ажиллах;
17. Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу ТБОНӨТХ-ийн дагуу хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, данснаас хасах, шилжүүлэх, зохицуулж байгаа боловч шийдвэрийн үндэслэх хэсэгт энэ журмын холбогдох заалтыг үндэслэж байх;
18. Автомашиныг балансаас балансад шилжүүлэх болон худалдахдаа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэх, хасах зохицуулалтыг шийдвэрт оруулж хэвших;
19. Шийдвэрийн хэрэгжилтийг хариуцах эзэн болон эргэн тайлагнах хугацааг тодорхойл шийдвэрт бичвэр оруулж байх.
20. Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлж байгаа тохиолдолд барилгын доорх газар эзэмших эрхийн хамт шийдвэрлэх; Ийнхүү шийдвэрлэхдээ Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолыг баримтлах,
21. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх асуудал болон Аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлүүлэх асуудалд гарах шийдвэрийн төсөл, танилцуулгыг бэлтгэж тухайн төсөл болон танилцуулгад “боловсруулсан”, “хянасан”, “танилцсан”, хурлаар оруулахыг зөвшөөрсөн албан тушаалтны нэр, гарын үсэг, огноог тусгаж, эдийн засгийн тооцоопол, эрх бүхий этгээдийн дүгнэлт зэрэг нэмэлт мэдээлэл, зураг, гэрчилгээ зэргийг хавсарган баримт бичгийн бүрдэл хангаж шийдвэрлүүлэх, эдгээр баримтыг батлагдсан шийдвэрийн хамт Орон нутгийн өмчийн газрын архивд хадгаламжийн нэгж болгон архивлаж хэвших;
22. Эрх зүйн зөрчилтэй байдлаас үүдэн гарах эрсдэлийг тооцдог байх;
23. ЗГХЭГ-ын Сангийн сайдын хамтарсан 204 тушаалаар батлагдсан журмын дагуу орон нутгийн өмчит байгууллагын үйлчилгээний автомашины тоо төрөл тогтоох асуудлыг хийгээгүй бөгөөд цаашид хэрэгжүүлэн ажиллах;
24. ИТХ-ын 2023 оны 01 дүгээр тогтоолоор баталсан Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам, төлбөрийн хэмжээг тогтоох тухай тогтоол нь хуульд нийцэхгүй байгаа бөгөөд цаашид дээрх журмыг хуульд нийцүүлэн хийх нь зүйтэй;
25. ТӨБЗГ-ын 2022 оны 65 тогтоолын 1.3-т “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ӨХБЗ-ийн үйл ажиллагааны журмыг энэхүү журамд нийцүүлэн баталж, мөрдүүлэхийг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга наарт зөвлөсүгэй гэж заасны дагуу аймгийн ИТХ-аар ӨХБЗ-ийг шинэчлэх; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.2.1, 31.4-д

- заасан Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журмыг баталж (ТӨБЗГ)-ын тогтоолоор баталсан журмыг ашиглаж болно) мөрдөж ажиллах;
26. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулж буй мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарчмыг баримтлан ажиллах;
 27. Төрийн хяналт шалгалтын тухай хууль 5 дугаар зүйлийн 5.2. “Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу хийх бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана.” мөн 5².1 дэх хэсэгт “Төлөвлөгөөт бус шалгалтыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр, түүнчлэн осол аваар, халдварт өвчин, хордлого зэрэг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулсан, учруулж болзошгүй нөхцөл үүссэн тохиолдолд болон хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр хийнэ.” гэж заасныг тус тус мөрдөж ажиллах;
 28. Аймгийн ИТХ нь аймгийн өмчийн өмчлөгч болохын хувьд хөрөнгөө зээмшүүлэх гэрээ, түүнийг дүгнэх журам, гэрээний сунгалтын загвар зэрэг асуудлыг нарийвчлан зохицуулах, гэрээг өмчийн программ хангамж ашиглаж дүгнэх, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, орон нутгийн өмчит байгууллагын удирдлагыг хариуцлагыг дээшлүүлэх;
 29. Аймгийн ОНӨГ-ын бүтэц орон тоонд хяналт шалгалт хариуцсан мэргэжилтний орон тоо батлагдсан тул Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор батлагдсан ОНӨГ-ын холбогдох ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтын дагуу хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжил арга зүйн зөвлөмжийн дагуу газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд энэ талаар зорилт арга хэмжээг төлөвлөн тусгаж хэрэгжүүлэх, өмч зээмшлийн гэрээ байгуулах, дүгнэх замаар орон нутгийн өмчид бүртгэлээр хяналт тавьж ажиллах зөвлөмж өгөх;
 30. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төсөл болон бусад холбогдох хуулийн шинэчлэлтэй уялдуулан орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрууд болон орон нутгийн өмчит компанийн статусыг тодорхой болгох, бүтэц, дүрэм, захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж, холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулан хэрэгжүүлэх, Орон нутгийн өмчийн газрын орон нутгийн өмчийн удирдлага, төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, орон нутгийн өмчит компанийн засаглал, үр өгөөжийг сайжруулах;
 31. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх талаар судалж, санал дүгнэлт боловсруулан ИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;
 32. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, орон нутгийн өмчит, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг холбогдох бусад материал, төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага,

- удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээллийг албан ёсны цахим хуудсанд байршуулах;
33. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулах, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулах, орон нутгийн өмчийг удирдах, орон нутгийн өмчийн газрын албан хаагчдыг чадавхжуулах, компанийн засаглал чиглэлээр сургалтад хамруулах арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;
34. “Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам”, “Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”, орон нутгийн өмчит компани, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам зэргийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулж, мөрдүүлэх;
35. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн гүйцэтгэх удирдлагуудтай Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д “...Өмчлөгч буюу түүнээс эрх олгогдсон этгээд нь өмчлөх эрхийнхээ тодорхой хэсгийг ажилтнаар дамжуулан хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлагын түвшний ажил үүрэг гүйцэтгүүлэх зорилгоор тухайн ажилтантай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулж болно...” гэж заасан заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ыг удирдлага болгон “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах;
36. Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллах чиглэлийг холбогдох албан тушаалтан болон орон нутгийн өмчит компани, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагуудад өгч ажиллах.

----- оОо -----